

Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ

1. “УДИРДЛАГЫН МАНЛАЙЛАЛ-2023” СУРГАЛТ, ЗӨВЛӨГӨӨН БОЛЛОО

Аймгийн Засаг даргын Тамгын газраас Дундговь аймгийн хөгжлийг тодорхойлоход манлайлал, уялдаа, хамтын ажиллагааг бэхжүүлж, нэгдсэн мэдээллээр хангах зорилгоор “Удирдлагын манлайлал-2023” хурал, зөвлөгөөнийг энэ сарын 30, 31-ний өдрүүдэд зохион байгуулсан. Уг сургалт зөвлөгөөнд сумын Засаг дарга, Засаг даргын орлогч, Тамгын газрын дарга, Байгууллагын дарга, эрхлэгч нар, Санхүүгийн албаны дарга нар оролцлоо.

Энэ үеэр илтгэлүүд болон жишиг сум, байгууллагуудын туршлагаас суралцсан юм. Мөн салбар хуралдаанууд, нөхөрсөг спортын тэмцээнийг зохион байгуулжээ. Түүнчлэн оролцогчдоос мэдлэг бататгах сорилуудыг авсан нь зөвлөгөөнийг үр дүнтэй, оролцоотой болгосон байна.



2. СУРГУУЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ЗУРАГЛАЛ БОЛОВСРУУЛАХ БАРУУН БҮСИЙН СУРГАЛТ АМЖИЛТТАЙ БОЛЖ ӨНДӨРЛӨЛӨӨ

Сургуулийн менежментийн зураглал боловсруулах, арга туршлага судлах сэдэвт 1,5 өдрийн 16 цагийн сургалтыг баруун бүсийн сургуулиудын хэмжээнд 2023 оны 11 сарын 06-07 ний өдрүүдэд Сайхан-Овоо сумын Ерөнхий боловсролын сургууль дээр амжилттай зохион байгууллаа.

Аймгийн Засаг даргын захирамжаар 2023 оныг "Боловсролыг дэмжих жил" болгон зарласантай холбогдуулан сургалтын зардал болох 3,000,000 төгрөгийг сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт "багш нарыг чадавхжуулах сургалт зохион байгуулах" гэж тусгагдсаны дагуу Засаг даргын нөөцөөс гарган сургагч багшийн зардал болон бусад арга хэмжээг санхүүжүүлж сумын боловсролын салбарыг дэмжин ажиллалаа.


Энэхүү сургалтад Эрдэнэдалай ЕБС, Дэлгэрхангай ЕБС, Сайхан-Овоо ЕБС, Мандал сургуулийн нийт 60 багш, удирдлагууд оролцлоо. Сургалтыг зохион байгуулсан Мандал сургуулийн хамт олон, болон арга хэмжээг санхүүжүүлсэн Сайхан-Овоо сумын Засаг дарга, түүний ажлын алба мөн хамтарч ажилласан Эрдэнэдалай, Дэлгэрхангай ЕБС-ийн багш, удирдлагуудад талархал дэвшүүлж, ажлын амжилт хүсье.



3. ОРОН НУТГИЙН БАЙГУУЛЛАГЫН САНХҮҮГИЙН АЖИЛТНУУДЫГ ЧАДАВХЖУУЛАХ СУРГАЛТАД ХАМРАГДЛАА

Дундговь аймгийн Засаг даргын тамгын газар, Сангийн яамтай хамтран “Орон нутгийн байгууллагын санхүүгийн ажилтнуудыг чадавхжуулах сургалт”-ыг Дундговь аймгийн орон нутгийн санхүүгийн нийт 78 албан хаагчийг хамруулан Улаанбаатар хотноо 2023 оны 11 дүгээр сарын 16-17-ны өдрүүдэд зохион байгуулсан. Тус сургалтанд манай байгууллагын Санхүүгийн албаны дарга Р.Тунгалагтуяа, Төсөв төрийн сангийн мэргэжилтэн Ч.Түвшинбаяр, ЗДТГ-ын нягтлан бодогч Г.Чагдарсүрэн, Э.Наранцэцэг, Нярав З.Шинэхүү нар оролцож шинэчлэн ашиглаж буй санхүү бүртгэлийн программ, бусад цахим системийн заавар зөвлөгөөг авч, түүнчлэн сайжруулах шаардлагатай саналуудаа хүргэж ажилласан байна.

Мөн HR Consulting клубын Хүний хөгжлийн сургалтад хамрагдаж Харилцаа хандлагын талаарх мэдлэг мэдээллийг олж авсан.





4. ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ӨДӨРЛӨГ 2023 АРГА ХЭМЖЭЭ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

2023 оны 11 дүгээр сарын 24-ны 14 цагт Сайхан-Овоо сумын Соёлын төвд жил болгон уламжлал болгон зохион байгуулдаг "Төрийн албан хаагчийн өдөрлөг 2023" арга хэмжээг амжилттай зохион байгууллаа. Тус арга хэмжээнд 65 албан хаагч оролцлоо. Баярын нээлтийг Сумын ИТХ-ын дарга Ц.Адъяа-Отгон нээж, ЕБС-ийн дуу хөгжмийн багш Гомбодэлгэр мэндчилгээ дэвшүүлэн амжилт үр бүтээлтэй ажиллаж буй албан хаагчдыг сумын 100 жилийн дурсгалын зүйлээр шагнав.

Мөн Монгол хэл бичгийн дүрмийн талаар Сургалтын менежер Р.Цэцэгмандах, Угийн бичиг хэрхэн хөтлөх түүний ач холбогдлын талаар Ахмадын хорооны дарга Д.Алтанцэцэг нар албан хаагчдад зориулж сургалтыг зохион байгууллаа.

Түүнчлэн Хэлний салбар зөвлөлөөс тус арга хэмжээн дээр албан хаагчдын дунд Эх хэлний танин мэдэхүйн уралдаан болох ТУНГААМАЛ тэмцээнийг зохион байгуулсан. Тус уралдаанд албан хаагчдыг 7 баг болгон хувааж мэдлэг чадвараараа өрсөлдлөө. 1-р байрыг Ц.Алтангэрэл ахлагчтай баг, 2-р байрыг Ц.Сарантуяа ахлагчтай баг, 3-р байрыг Ц.Адъяа-Отгон ахлагчтай баг тус тус эзэлсэн.

Тус арга хэмжээнд оролцсон нийт төрийн албан хаагч нартаа болон зохион байгуулсан ЗДТГ-ын ажлын албанд талархал илэрхийлье.



